**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 19 өдөр Дугаар 100 Номгон

# Үндсэн хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах суудлын автомашины доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Автомашины дуудлага худалдааг холбогдох хууль журмын дагуу 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 11.00 цагт аймгийн Орон нутгийн өмчийн газрын 114 тоот өрөөнд зохион байгуулж орлогыг Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-ний данс болон аймгийн Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх, ;

2.2 Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2018 оны 11 дүгээр сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

0118135

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын
19-ний өдрийн 100 дугаар тогтоолын хавсралт

## НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Аймаг, сумын нэр | Байгууллагын нэр | Тээврийн хэрэгслийн төрөл | Марк | Улсын | | Ашиглалтад орсон огноо | Тээврийн хэрэгслийн | | | Дуудлагаар худалдах доод үнэ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сери | дугаар | | арлын дугаар | моторын дугаар | моторын ээлэхүүн /см$^3$/ | | |
| 1 | Баянхонгор аймаг | Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК | Суудлын автомашин | Toyoto land cruizer | БНА | 99-11 | 11.01.10 | NDJ810045011 | | B4160 | 5 000 000,0 | 1994 онд үйлдвэрлэгдсэн 2010 онд Монголд орж ирсэн 32 399 091 төгрөгөөр худалдаж авсан үлдэгдэл өртөг 2 993 877 төгрөг, 2017 онд 1763636 төгрөгөөр 4 дугуй тавьсан. |
| 2 | Баянхонгор аймаг | Нэгдсэн эмнэлэг | Суудлын автомашин 7000,0 | nissan advan | БНА | 94-88 | 09.12.01 | YFY11-211996 | | B1490 | 800 000,0 | Анхны өртөг 7870000 төгрөг элэгдлээ 100% нөхсөн. 2001 онд үйлдвэрлэгдсэн, 2008 онд Монголд орж ирсэн |
| 3 | Баянхонгор аймаг | Нэгдсэн эмнэлэг | Суудлын автомашин /Хятад жип/ | Tianma suu fengch | БНА | 98-88 | 10.12.30 | LHA6J02DXAA006598 | E33474 | B2237cc | 1 500 000,0 | Анхны өртөг 23800000 төгрөг элэгдлээ 100% нөхсөн. 2010 онд үйлдвэрлэгдсэн |

оОо